



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 27 өдөр

Дугаар A/533

Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх
чиглэл, жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.4 дэх зорилтын 9 дэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны жагсаалт"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны жагсаалтад дурдсан үйл ажиллагааг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, эрүүл мэндийн талаарх үндэсний хөтөлбөрүүд, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж, холбогдох санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо судалгаа гарган төсөвтөө тусган, хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл боловсруулах, төсөл хэрэгжүүлэгчийг шалгаруулах, хэрэгжилтийг зохицуулах, гэрээ байгуулах, хяналт тавих, тайлан хүлээн авахтай холбогдсон зааврыг 2018 оны 2 дугаар улиралд багтаан боловсруулахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Р.Оюунханд/-т үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11 сарын 27 ны өдрийн
A/533 дугаар тушаалын хавсралт

Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн
түншлэлийн тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны жагсаалт

Нэг. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл

1. Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ;
2. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ;
3. Хүний нөөцийн хөгжил;
4. Эрүүл мэндийн санхүүжилт, хөрөнгө оруулалт;
5. Эрүүл мэндийн технологи, чанар;
6. Эм зүйн тусlamж, үйлчилгээ;
7. Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага;
8. Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал.

Хоёр. Тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөгжүүлэх түншлэлийн үйл ажиллагааны жагсаалт

“Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ” чиглэлийн хүрээнд:

1. Халдварт болон халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгаа;
2. Халдварт болон халдварт бус өвчиний эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ;
3. Заавал болон тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалт, халдварт өвчиний голомтын ариутгал, халваргүйтгэлийн үйлчилгээ;
4. Шүд, амны хөндийн өвчинөөс сэргийлэх, өвчлөлийг бууруулах мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн арга хэмжээ;
5. Шүд, амны хөндийн өвчинийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эмчилгээ;
6. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгаа;
7. Ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилт, тэтгэвэрт гарах үеийн сэтгэл зүйн хувьд бэлтгэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа;
8. Хүн амыг уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах мэдлэг, арга барилтай болгох мэдээлэл, сургалт сурталчилгаа, ухуулга нөлөөллийн арга хэмжээ;
9. Орчны эрүүл мэндийг хамгаалах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй амьдралын орчинг бүрдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл;

10. Ундны усны чанар, аюулгүй байдал, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга, нөлөөллийн арга хэмжээ;

11. Хөрсний бохирдолтыг бууруулах хөрсний эрүүл ахуйн үзүүлэлтүүдийг сайжруулах нүхэн жорлон, угаадасны нүхний стандартыг мөрдүүлэх олон нийтийн ухуулга нөлөөллийн арга хэмжээ;

12. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, үр дагаврыг арилгуулах арга хэмжээ;

13. Эсэн мэнд амьдрахуй, амаржихуйн хандлага, дадлыг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа;

14. Бэлгийн болон нөхөн үржихуйн эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа;

15. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бүрдүүлэх;

16. Донорын эгнээг өргөжүүлэх, донорын үйлсийг сурталчилдах, нялх, балчир хүүхдийн хооллолтын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл.

“Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ” чиглэлийн хүрээнд:

1. Өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэх тусlamж, үйлчилгээ;

2. Сувилахуйн болон сэргээн засахын дагнасан (хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн сэргээн засахын болон сувилахуйн) тусlamж, үйлчилгээ;

3. Гэрээр үзүүлэх сувилахуйн тусlamж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ (мэс засал, хими эмчилгээ);

4. Аймаг, нийслэлийн хүн амд үзүүлэх үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээний ачаалал хуваалцах, дутууг нөхөх бүх төрөл (өдрийн эмчилгээ, уламжлалт анагаахын тусlamж, үйлчилгээ, бусад)-ийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээ;

5. Улсын төсвөөс санхүүжих эх барихын, эмнэлгийн мэргэшсэн (хүүхдийн, гэмтэл, хорт хавдар, сэтгэцийн эмгэг, халдварт өвчин), эмнэлгийн яаралтай болон түргэн тусlamжийн үйлчилгээ;

6. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний багцад хамаарах тусlamж, үйлчилгээ;

7. Уламжлалт анагаахын болон орчин үеийн анагаах ухааны хосолсон эмнэлгийн тусlamж, үйлчилгээ;

8. Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчний үеийн эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээ;

9. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын барилгын ерөнхий болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, хоол, угаалга, ариутгал, цэвэрлэгээ, харуул хамгаалалт.

“Хүний нөөцийн хөгжил” чиглэлийн хүрээнд:

1. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, нөхөн олгох, хүчингүй болгох үйл ажиллагаа;

2. Төгсөлтийн дараахь сургалт эрхлэх, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа;
3. Эрүүл мэндийн ажилтны харилцаа, хандлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг сайжруулах сургалт, сурталчилгаа;
4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг хангах, эрүүл мэндийн ажилтныг ажлын байрны эрсдлээс хамгаалах, хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа.

“Эрүүл мэндийн санхүүжилт, хөрөнгө оруулалт” чиглэлийн хүрээнд:

1. Эмнэлгийн барилгын зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, дэд бүтцийг байгуулах, өргөтгөх, шинэчлэн засварлахад хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
2. Дэвшилтэт технологи бүхий эдийн засгийн үр дүнтэй хамтарсан үйлдвэр байгуулах;
3. Уул уурхай, аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг бууруулах нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусамж, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийх;
4. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын байгууламж байгуулах;
5. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх.

“Эрүүл мэндийн технологи, чанар” чиглэлийн хүрээнд:

1. Цөм технологийн төсөл хэрэгжүүлэх, өртөг шингэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэвтрүүлэх;
2. Хүний биобэлдмэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх;
3. Өвчинөөс урьдчилан сэргийлэх, өвчний оношилгоо, эмчилгээний технологи нэвтрүүлэх, эрүүл, аюулгүй орчныг хангах талаар судалгаа, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх;
4. Уламжлалт анагаах ухааны нотолгоонд суурилсан эдийн засгийн үр дүнтэй, санхүүгийн үр ашигтай нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээний технологи нэвтрүүлэх;
5. Анагаах ухааны нотолгоонд суурилсан, эдийн засгийн үр дүнтэй уламжлалт болон орчин үеийн анагаахын ухааны хосолсон эмнэл зүйн удирдамж боловсруулж нэвтрүүлэх;
6. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, засвар үйлчилгээ, чанар, аюулгүй ажиллагааны баталгаажилт;
7. Лабораторийн чанарын баталгаажилт;
8. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарыг хөгжүүлэх, эмнэл зүйн хөтөч, удирдамж, стандарт боловсруулах;
9. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх эрдэм шинжилгээ, судалгаа;
10. Эмийн үйлдвэрлэл, хангамж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар судалгаа, шинжилгээ.

“Эм зүйн чанар, аюулгүй байдал” чиглэлийн хүрээнд:

1. Эмийг бүртгэх, баталгаажуулах үйл ажиллагаа;
2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйлчилгээ;
3. Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн шугамаар нийлүүлсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээн авах, хадгалах, түгээх үйл ажиллагаа;
4. Эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх;
5. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилга, ухуулга нөлөөлөл;
6. Импорт орлох өрөнхий нэршлийн эм үйлдвэрлэл, ханган нийлүүлэх үйл ажиллагаа.

“Мэдээллийн технологи, мэдээллийн удирдлага” чиглэлийн хүрээнд:

1. Эрүүл мэндийн мэдээллийн кибер аюулгүй ажиллагаа, мэдээллийн технологийн зарим үйлчилгээ;
2. Эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтцийг байгуулах, мэдээллийн удирдлагыг гүйцэтгэх үйл ажиллагаа.

“Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт, ил тод байдал” чиглэлийн хүрээнд:

1. Эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшилийн түншлэлийн удирдлага, эмнэлгийн удирдлага (чанарын хөгжил, эрсдэл), эмнэлгийн бие даасан засаглал, төлөөлөн удирдах зөвлөл, эмнэлзүйн менежмент, эмнэлгийн худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн хөгжил, өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага, эрүүл мэндийн санхүүжилт, төлбөртэй үйлчилгээний тариф тогтоох, эрүүл мэндийн тооцоо аудит, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт тогтоох, чанарыг хөгжүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт;
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын удирдлагыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн (захиргаа, санхүү, олон нийттэй харилцах, хүлээн авах, мэдээллийн удирдлага) удирдах, ажиллуулах үйл ажиллагаа;
3. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын удирдлага, үйл ажиллагаа;
4. Эрүүл мэндийн байгууллага шинээр байгуулах, эрүүл мэндийн байгууллагын одоогийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагын зориулалтын барилга байгууламж барих, өргөтгөх, зориулалтаар өөрчлөн засварлахад хийх хэрэгцээний үнэлгээ;
5. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилт болон албан даалгаврын гүйцэтгэлд тавих хяналт;
6. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлд бэлтгэх сургалт явуулах, тусламж, үйлчилгээний үр дүнд чанарын үнэлгээ хийх, магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагаа;

7. Магадлан итгэмжлэлийн болон тусгай зөвшөөрлийн шинжээчийн сургалт;
8. Эрүүл мэндийн тухай багц хууль тогтоомж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт (сангийн орлого, зарлагад хяналт тавих)-эд олон нийтийн дэмжлэгт хяналт;
9. Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх үйл ажиллагаа;
10. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд үйлчлүүлэгч, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах, салбарын үйл ажиллагааг үнэлэх үйл ажиллагаа.